

ОРЧУУЛАХ ЧАДВАР ЭЗЭМШҮҮЛЭХ ТУХАЙД

Б. Батчимэг¹

Энэхүү өгүүлэлдээ гадаад хэлний сургалтанд орчуулгын хичээлийн гүйцэтгэх үүрэг, орчуулгын чадвар эзэмшүүлэх нь ямар ач холбогдолтой болох тухай өгүүлэхийг зорьлоо.

Оршил

Орчин цагт гадаад хэл сонирхон судлах хүмүүсийн тоо улам бүр өсөн нэмэгдэх болсон нь юуны өмнө даяарших үйл явцтай холбоотой. Дэлхийн улс орнуудын харилцаа өргөжин тэлэхийн хэрээр ард түмнүүдийн найрамдал нөхөрлөл бэхжин нийгэм, соёл урлаг, спорт зэрэг олон салбар чиглэлээр хамтран ажиллах эрмэлзэл улам бүр нэмэгдэж хүмүүс гадаад хэл, түүний дотор түгээмэл нийтлэг хэлийг идэвхтэй судлах боллоо. Түгээмэл хэлнээс зарим нэг нь тухайлбал: англи хэл дэлхийн ард түмнүүдийн харилцааны гол хэрэгсэл болов. Иймээс англи хэлний сургалтын материал, ном сурах бичиг, сургалтын аудио, видео, дижитал техник хэрэгслийн үйлдвэрлэл хурдтай хөгжлөө.

1990-д оноос өмнө гадаад ертөнцийг зөвхөн “ЗХУ” (хуучнаар) хэмээх цорын ганц цонхоор харж байсан Монголын ард түмний мэлмий ардчиллын буянаар нээгдэж дэлхийн улс орнуудтай идэвхтэй харилцах болсон билээ. Ийнхүү эрчимтэй харилцахад англи болон бусад түгээмэл хэл чухал үүрэг гүйцэтгэх учир эдгээр хэлний сургалтанд ихээхэн ач холбогдол өгөх болов. Англи хэлний багш бэлтгэх, бүх шатны сургуулиудад англи хэл заах, англи хэлний ном сурах бичиг, сургалтын техник хэрэгслийн хангамжийг сайжруулах талаар бодлого хэрэгжүүлсний үр дүнд өнөөдөр Монгол улсад англи хэлний мэдлэгтэй иргэдийн тоо улам бүр нэмэгдлээ. Зөвхөн англи хэл бус франц, герман, япон солонгос, хятад, орос гэх мэт түгээмэл хэлийг идэвхтэй судлах болсон.

Гадаад хэлний сургалтын гол хэрэглэгдэхүүн болох ном, сурах бичгийн эрэлт хэрэгцээ ч урьд өмнө байгаагүйгээр нэмэгдлээ. Ном сурах бичгийн эрэлтийг дотооддоо эрдэмтэн, багш нарын зохиосон ном сурах бичгээр, мөн импортын ном сурах бичгээр хангаж байна.

Гадаад хэлний сургалт ийнхүү эрчимжиж, зарим нэг талаар ахиц дэвшил гараад, гадаад хэлний боловсрол олгох үндэсний боловсон хүчин төлөвшөөд, ном сурах бичгийн хувьд ч зохих хэмжээнд хэрэгцээгээ хангаад байхуйц болсон өнөө үед бидэнд зайлшгүй эргэж харах шаардлагатай нэг асуудал тулгараад байгаа нь өмнө дурьдсанчлан орчуулах чадварын тухай юм. Асуудлын гол нь юунд оршиж байгаа, орчуулах чадвар эзэмшүүлэхийн

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш

ач холбогдол зэргийн талаар энд өгүүлэх болно. Юуны өмнө гадаад хэл, түүний дотор англи хэлний өнөөгийн сургалтын түгээмэл аргын тухай товч авч үзье.

Нэг: Гадаад хэлний сургалтын аргын тухай

19-р зууны дунд үед барууны орнуудад гадаад хэлний хэлзүйн орчуулгын аргыг² хэрэглэдэг байжээ. Оюутан сурагчдад уран зохиолын хам сэдвүүд орчуулах даалгавар өгч үүгээр дамжуулан тухайн хэлний хэлзүйн мэдлэгийг эзэмшүүлдэг байна. Энэхүү аргыг өнөөдөр дэлхийн зарим нэг улсууд гадаад хэлний сургалтандаа хэрэглэдэг. Тэдгээрийн нэг нь Япон улс юм. Харин бусад ихэнх улсуудад оюутан суралцагчдад бэрхшээлтэй, ойлгомжгүй, үр дүн муутай энэхүү аргаас яваандаа татгалзаж ярианы чадвар эзэмшүүлэхийг чухалчилдаг болсон. Манай улсад ч гадаад хэлний сургалтандаа ярих, сонсох, бичих, унших чадварыг хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулж ирсний ачаар тодорхой амжилтанд хүрсэн.

Гадаад хэлний сургалтанд суралцагчийн ярианы чадварыг хөгжүүлэхэд гол анхаарал хандуулдаг. Хэлний хичээл дээр эх хэлээрээ ганц ч үг хэлэхгүй зөвхөн тухайн харь хэлээр харилцах шаардлага тавигддаг. Хэл харилцааны хэрэглүүр болохын хувьд бол мэдээж хэрэг ийм чадварыг хөгжүүлэх нь чухал гэдэгтэй хэн ч маргахгүй. Харин эх хэлийг нь ийм төрлийн хичээл дээр хориглосноор эх болон гадаад хэлний хооронд утгыг холбон ойлгох хамгийн чухал чадварыг огт эзэмшүүлэхгүй орхидог.

Дунд сургуулийн түвшинд орчуулгын чадвар эзэмшүүлэх, үүний тулд орчуулгын аргыг ашиглах нь төвөгтэй учраас асуудлыг их дээд сургуулийн түвшинд авч үзэх нь зүйтэй.

Хоёр: Их дээд сургуулийн англи хэлний сургалтын талаар

Орчуулагч, хэлмэрчийн мэргэжлийн сургуулиас бусад сургуульд англи хэлний сургалтанд орчуулах дадал чадвар эзэмшүүлэхэд анхаарал хандуулдаггүй гэхэд хилсдэхгүй. Тавигдаж буй энэхүү асуудлыг бүрэн нотлохгүй ч нөхцөл байдлыг тодруулахад нэмэр болгох үүднээс Улаанбаатар хотноо үйл ажиллагаагаа явуулдаг хэд хэдэн орчуулгын товчооноос судалгаа авлаа. Судалгаагаар орчуулгын товчоодоор үйлчлүүлэгчдийн ажил мэргэжлийн байдал, орчуулгын материалын төрөл зүйл зэргийг тодруулах асуулга явуулахад Ж: 'Boundless Education' Нийгэмлэгийн дэргэдэх орчуулгын товчоогоор 2011-2012 оны хичээлийн жилд үйлчлүүлсэн хэрэглэгчдийг ажил мэргэжлээр нь ангилж үзэхэд нийт үйлчлүүлэгчдийн 95 хувь нь оюутнууд байжээ. Орчуулга хийлгэхээр өгсөн эх материалыг мэргэжлийн чиглэлээр ангилж үзэхэд эдийн засаг, санхүүгийн чиглэлийн материал 40 орчим хувийг, түүх, нийгэм, соёл, гүн ухаан гэх зэрэг хүмүүнлэгийн шинжлэх ухааны чиглэлийн материал 38 орчим хувийг, үлдсэн 22 хувийг хууль, хөдөө аж ахуй, хүнсний технологи, барилга, уул уурхай, математик, техникийн чиглэлийн материалууд эзэлж байсан бөгөөд орчуулах материалыг хэлээр нь ангилахад англи хэлнээс монгол хэлэнд, эсвэл монгол хэлнээс англи хэлэнд орчуулах материал нийт захиалгын 90 гаруй хувийг, орчуулгын эрэлтийг цаг хугацаагаар нь авч үзэхэд 11-р сарын дунд үеэс 1-р сарыг дуустал хугацаанд хамгийн өндөр үзүүлэлттэй буюу жилийн ажлын нийт ачааллын 60 хувийг тус тус эзэлж байна. Хавар 4-5 сарын хугацаанд мөн орчуулгын эрэлт нэмэгддэг ч өвлийн улиралтай харьцуулахад харьцангуй бага байдаг гэжээ.³

² www.wikipedia

³ 'Boundless Education' Нийгэмлэгийн дэргэдэх орчуулгын товчооны 2011 оны сүүл, 2012 оны улирлын тайлан

Өнөөдөр Монгол улсад англи хэл нь заавал судлах гадаад хэлэнд тооцогддог бөгөөд англи хэлний мэргэжлийн сургуулиас бусад сургуульд ихэнхдээ 2-3 улирал ордог. Энэ хугацаанд голчлон хэлзүй, ярианы чадвар, мэргэжлийн чиглэлийн нэр томъёоноос бүрдсэн үгсийн сангийн мэдлэг олгодог. Нэг талаас сургалтанд орчуулах чадвар эзэмшүүлэх асуудлыг ийнхүү орхигдуулдаг, нөгөө талаас хэлний бус мэргэжлийн их дээд сургуулийн оюутнуудын дунд гадаад хэлэнд хоёрдугаар зэргийн ач холбогдол өгөх байдал түгээмэл байдаг нь тэдний гадаад хэл сурах идэвхийг бууруулдаг зэрэг олон хүчин зүйл хэлний мэргэжлийн бус их дээд сургуулийн оюутны англи хэлний мэдлэг, ялангуяа орчуулга хийх чадвар сул байхад нөлөөлдөг байх. Мөн “орчуулга хийхэд хоёр хэлний мэдлэгтэй байхад л хангалттай” хэмээх ойлголт нийгэмд газар авсан нь гадаад хэлний сургалтанд харилцааны тав дахь чухал чадвар болох орчуулгын дадал чадварыг үл тоомсорлоход хүргэсэн хүчин зүйлийн нэг байж болох юм. Үнэн хэрэгтээ аль нэгэн гадаад хэлний тодорхой шатны мэдлэг чадвар эзэмшсэн л бол тухайн харь хэл болон эх хэлний хооронд орчуулга хийх чадвартай боллоо гэсэн үг биш юм.

Гурав: Орчуулгын дадал чадварын тухай

Орчуулга бол хүний үйл ажиллагааны эртний хэлбэрүүдийн нэг юм. Хүн төрөлхтний түүхэн хөгжлийн явцад өөр хоорондоо ялгаатай хэлээр хэлэлцэгч омог бүлгүүд үүсэж улмаар тэд хоорондоо ойлголцох шаардлага тулгарснаар тэдний хооронд зуучлах хэлмэрчид гарч иржээ.⁴ Орчуулагч хэлмэрчдийн ачаар дэлхийн бусад улс орны ард түмний харилцан ойлголцол, найрамдал нөхөрлөл өргөжин тэлсэн.

Орчин цагт ч дэлхийн улс түмнүүдийн харилцаанд орчуулга чухал үүрэг гүйцэтгэж байна. Өнөөдөр бид дэлхийн олон улс орны ард түмний соёл, боловсрол, шинжлэх ухааны ололт амжилтын талаарх мэдээллийг цаг алдахгүй хүлээн авч байна. Даяаршил хүчтэй өрнөж, дэлхийн улс орнуудтай Монгол улсын харилцаа, хамтын ажиллагаа олон салбарт ийнхүү идэвхжиж байгаа өнөө үед их дээд сургуульд суралцаж байгаа олон мянган залууст орчуулах чадвар эзэмшүүлэх, үүний тулд англи хэлний сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Өнөө үед англи хэлний хэрэгцээ шаардлага асар ихээр нэмэгдэж байна. Орчин үеийн шинжлэх ухаан, технологийн хөгжил, ололт амжилт мэдлэг мэдээллийн ихэнхийг англи хэлээр дамжуулан авч байгаа учраас бүх нийтийн англи хэлний мэдлэгийг зөвхөн өдөр тутмын яриа, харилцааны хүрээнд бус анхан шатны түвшинд орчуулах чадвар төлөвшүүлэхэд чиглүүлэх нь зүйтэй. Англи хэлээр хэвлэгдсэн сонин сэтгүүл мэргэжлийн ном, сурах бичгээс өөрт шаардлагатай мэдээллийг олж уншиж орчуулах чадвар олгосноор эх хэлний мэдлэгийг ч давхар сайжруулах боломжтой болно. Ингэж чадвал сүүлийн үед найруулга дорой, утга ойлгомжгүй, болхи орчуулгаас шалтгаалан монгол хэлний дархлаа суларч байгаа байдлаас аврагдах болно.

Сүүлийн үед хүүхэд залуусын эх хэлний мэдлэг муу боллоо, этгээд гаж үгээр ярих боллоо гэж шүүмжлээд байгаа боловч цаад шалтгааныг тэр бүрий олж харахгүй байна. Хэргийн гол учир орчуулах чадвар эзэмшүүлэхгүй орхиж байна гэдгийг бид дээр өгүүлсэн

⁴ Андрей Паршин “Теория и практика перевода” Бүлэг 1, Хуудас 1

билээ.

Хэлний мэргэжлийн бус их, дээд сургуулийн оюутанд орчуулах чадвар эзэмшүүлэхдээ мэдээж хэрэг анхан шатны хүрээнд л эзэмшүүлэх боломжтой гэдгийг санаж сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг маш ухаалгаар төлөвлөх нь зүйтэй.

Хамгийн наад зах нь гэхэд толь бичигтэй ажиллуулж сургах хэрэгтэй байна. Олон төрлийн толь бичиг, тайлбар толиуд байдаг боловч түүнээс алийг нь хэрхэн яаж ашиглах, үгийг хэрхэн зөв оноож буулгах талаар зохих мэдлэг эзэмшээгүйн улмаас тухайн толь бичигт өгөгдсөн хамгийн эхний утгаар буулгах нь элбэг. Энд нэг жишээ дурьдая. “Marco Polo who has lived for 20 years in Khubilai’s Court returned home”. Энэ өгүүлбэрийг Марко Поло Хубилай хааны шүүхэд хорин жил амьдраад гэртээ харив гэж орчуулсан байх бөгөөд оюутан ‘court’ гэдэг үгийг толь бичигт: 1. Шүүх, 2. Талбай, 3. Хааны ордон, 4. Теннисний талбай гэх зэргээр буулгасан олон утгаас хамгийн эхний утгаар нь авч хэрэглэснээр өгүүлбэр огт өөр утгатай болжээ. Зүй нь Марко Поло Хубилай хааны ордонд 20 жил амьдраад нутаг буцав гэх хэрэгтэй байсан. Тухайн тохиолдолд оюутан өгүүлбэрийн утгыг ойлгоод тохирох үгийг сонгосон бол “хааны ордон” гэдэг үгийг төвөггүй сонгох байсан. Иймэрхүү жишээ олныг дурьдаж болно.

Манайд орчуулгын мэргэжлийн сургуульд англи монгол хэлний орчуулгын хичээл заадаг практикаас ажиглахад ихэнх тохиолдолд тухайн хам сэдвийн хүрээнд тухайн оюутнуудад шинэ үг хэллэгийг багш орчуулж өгсний дараа оюутнууд бие даан орчуулах байдал зонхилдог. Энэ байдлыг өөрчлөх хэрэгтэй гэж үзэж байна. Юуны өмнө тухайн орчуулах хам сэдвийн хүрээнд өгүүлбэр бүрийн түвшинд нарийн шинжилгээ хийж, тухайн өгүүлбэрийн бүтцийг ойлгох чадвар эзэмшүүлэх хэрэгтэй. Нэгэнт өгүүлбэрийн бүтэц, өгүүлж байгаа санааг ойлгосон бол дараа нь үг хэллэгийн түвшинд зохих хувиргалтыг төвөггүй хийх боломжтой болно. Орчуулга хийх явцад оюутан тухайн өгүүлбэр, үг хэллэгийг эх хэлтэйгээ байнга холбож үзэх учир үүний ачаар эх хэлний мэдлэг нь сайжирна.

Тиймээс хэлний мэргэжлийн бус сургуулийн англи хэлний хичээл заахдаа орчуулгын чадвар дадал эзэмшүүлж өгүүлбэрийн бүтцийг олж ойлгох, толь бичгээс үг хайхдаа үгийг зөв оноож сонгох чадвар эзэмшүүлэхэд гол анхаарлаа хандуулвал зохино.

НОМ ЗҮЙ

1. Казакова Т.А. Практические основы перевода. English - Russian. - СПб.: Союз. - 2002. - 320 с. - (Изучаем иностранные языки). Электронная книга.
2. Е.В Бреус. "Теория и практика перевода с английского на русский" Учебное пособие 2-е изд, испр., и доп, - М: Изд-во УРАО, 2000. 208 с
3. В.А. Комиссаров, А.П Коралова “Практикум по переводу с английского языка на русский” Москва, Высшая школа, 1990
4. Андрей Паршин “Теория и практика перевода” ” Учебное пособие М: 2002